

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5¹ дэх хэсэг нэмсүгэй:

“22.5¹.Энэ хуулийн 22.4.2 дахь заалтад заасан бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлсэн нөхцөл, боломжийг хангасан эсэх асуудлыг нягтлахдаа Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын санал, дүгнэлтийг авна.”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.5.Энэ хуулийн 9.3-т заасан зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах төлөөллийг оруулсан байна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “бүрдэнэ.” гэсний дараа “Орон тооны бус нэг гишүүнийг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын саналыг үндэслэн томилно.” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “болон ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн” гэснийг “байгууллага болон Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Монголын” гэсний дараа “Үндэсний” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Худалдаа” гэснийг “Монголын Үндэсний худалдаа” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.2 дахь заалтын “албаны төлөөлөл,” гэсний дараа “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “мэргэжлийн холбоод” гэснийг “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.2 дахь заалтын “нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;” гэснийг “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон нийгэмд үйлчлэх хоёр хүртэлх төрийн бус байгууллагаас;” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.10 дахь хэсэг нэмсүгэй:

“16.10. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, хяналт тавих чиг үүргийг Засгийн газрын шийдвэрээр Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаар хариуцуулан гүйцэтгүүлж болно.”

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн “бүрэлдэхүүнд” гэсний дараа “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн “тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн,” гэснийг “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “хөрөнгө оруулагчдын” гэсний дараа “болон Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “Эвлэрүүлэн зуучлалыг” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол эвлэрүүлэн зуучлалыг” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Энэ” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.5.Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хувийн хэвшлийн төлөөллийг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим төлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 13.5.20 дахь заалт нэмсүгэй:

“13.5.20. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас үзүүлэх үйлчилгээ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмсүгэй:

“14.4.Инновацийн төслийг бүртгэх чиг үүргийг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимд шилжүүлж болно.”

2 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “холбогдох байгууллагатай хамтран” гэсний өмнө, мөн зүйлийн 7.1.11 дэх заалтын “холбогдох байгууллагатай хамтран” гэсний өмнө “Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтын “дүгнэлт гаргах,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹.2 дахь хэсгийн “эвлэрүүлэн зуучлагч” гэсний дараа “, эсхүл талууд хүсэлт гаргасан тохиолдолд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагч” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим нь 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим төрийн бус байгууллага байна.

2 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан нийт ашгийн төлөө хуулийн этгээдийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 5 дугаар зүйлийн 5.15 дахь хэсэгт заасан мэдээллийг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимд хүргүүлнэ.

3 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу хуралдах Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын анхдугаар их хурлыг тус хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 180 хоногийн дотор зарлан хуралдуулж, тус танхимын дүрмийг шинэчлэн батлана.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан анхдугаар их хурлын төлөөлөгчдийг сонгоход Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.2-т заасан журмыг баримтлахгүй бөгөөд анхдугаар их хурлын төлөөлөгчдийг сонгох түр журмыг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Удирдах зөвлөлөөс тогтооно.

5 дугаар зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан дагнасан худалдаа, аж үйлдвэрийн танхимын тоо 15 ба түүнээс дээш болсноос хойш Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Удирдах зөвлөлөөс ээлжит их хурлыг зарлан хуралдуулна.

6 дүгээр зүйл.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль батлагдсанаас хойш тус хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын

зөвшөөрөлгүйгээр тус хуулийн 6 дугаар зүйлд хамаарах хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах, бүртгэхийг хориглоно.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг